



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 87/04

Улаанбаатар хот

Онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг
шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалт, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/26 дугаар тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлтийг хангаж Таеквондогийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон сурагчид, бэлтгэсэн багшийг шагнаж урамшуулсугай.

2. Шагналд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд зарцуулагдах 2,720,000 (хоёр сая долоон зуун хорин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД